

Төсөөллийг тань төгөлдөржүүлэ

PCDP

Төслийн менежмент, барилга угсралтын менежмент
Барилга угсралт
Зураг төсөл
Мэргэжилтнүүд




ПиСиДиПи ХХК нь 2013 оны 1 дүгээр сард Барилгын төслийн менежмент, Зураг төслийн зөвлөх үйлчилгээ, Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан үндэсний төслийн менежментийн компани юм. Одоогийн байдлаар бид дотоодын болон олон улсын 110 гаруй төсөлд амжилттай оролцон, захиалагчийн хүлээлт, шаардлагыг хангасан баталгаат гүйцэтгэлийг хүлээлгэн өгөөд байна.

Манай компаний үндсэн үйл ажиллагаа нь захиалагчийн зүгээс төсөлд тавих чанар, хугацаа, төсөв болон тэдний хэрэгцээ, шаардлагад тулгуурлан төслийн судалгааны үе шатнаас эхлэн иж бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх хүртэлх бүх үе шатны үйл ажиллагаа болон түүний аль нэг үе шатны ажлыг Захиалагчид хамгийн бага ачаалалтайгаар, хамгийн бага эрсдэлтэй байхаар төлөвлөн удирдах, гүйцэтгэлийг хянахад чиглэдэг.

ПиСиДиПи ХХК нь төслийн эхний өдрөөс эхлэн мэргэжлийн Зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бие даасан зөвлөх компани болон захиалагч, хөрөнгө оруулагчийн зөвлөх байр сууринаас хамтран ажилладаг. Эдгээр төслүүдэд олон нийтийн, орон сууцны, эмнэлгийн, боловсролын, зогсоол болон агуулахын, шашны, уул уурхайн болон үйлдвэрийн, дэд бүтцийн барилга байгууламжууд, мөн түүнчлэн гүүр хоолойн барилга байгууламжууд багтана.

Бизнесийн ёс зүй, шударга байдлыг эрхэмлэн Үйлчлүүлэгч, Захиалагч, Хөрөнгө оруулагчаа дээдлэн хүндэлж, хөрөнгө оруулалтыг зөв зохистой эдийн засгийн үр ашигтайгаар чиглүүлэн, тэдний хүлээлт, шаардлагад нийцсэн чанартай, аюул осолгүй, байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ.

Байгууллагын бүтэц





Төслийн менежмент, барилга угсралтын менежмент

Төслийн менежмент

- Захиалагчийн харилцаа
- Төслийн хүрээг тодорхойлох
- Төлөвлөлт
- Нөөцийн менежмент
- Ханган нийлүүлэлтийн менежмент
- Мастер график
- Урьдчилсан төсөв
- Төсөв гаргах
- Гэрээний менежмент
- Гэрээний нөхцөл боловсруулах
- Гэрээний шаардлага болосруулах
- Тендерийн материал бэлдэх
- Гүйцэтгэгчийн менежмент
- Өөрчлөлтийн менежмент
- Зардлын хяналт
- Ашиглалтанд оруулах
- Төслийг хүлээлгэн өгөх

Барилга угсралтын менежмент

- Зураг төслийн уялдааг хангах
- Барилга угсралтын төлөвлөгөө
- Нарийвчилсан график
- Технологийн судалгаа
- Технологийн карт
- Ажлын аргачлал
- ХАБЭА менежмент
- Чанарын менежмент
- Тайлан
- Гүйцэтгэлийн зураг
- Талбайн хяналт
- Шалгалт туршилт
- Ашиглалтанд оруулах зэрэг болон бусад ажил үйлчилгээг хийж гүйцэтгэнэ



Барилга угсралт

- Иж бүрэн барилга угсралт (түлхүүр хүлээлгэн өгөх нөхцөлтэй)
- Газар шорооны ажил
- Төмөр бетон бүтээц, ган бүтээц угсралт
- Интерьер, дотор заслын ажил
- Хавтгай болон налуу дээвэр
- Гадна тохижилт
- ХАС
- Хөргөлтийн систем
- Усан хангамж, ариутгах татуурга
- Холбоо дохиолол, автоматик
- Гадна иж бүрэн инженерийн шугам сүлжээ



Зураг төсөл

- Зураг төслийн менежмент
- Архитектурын зураг төсөл
- Барилга бүтээцийн зураг төсөл
- Цахилгааны зураг төсөл
- Халаалт агаар сэлгэлт
- Усан хангамж, ариутгах татуургын зураг төсөл
- Холбоо дохиоллыг зураг төсөл
- Автоматжуулалтын зураг төсөл
- Барилгын мэдээлэлтэй загварчлал (BIM)
- Гэрэлтүүлгийн загвар
- Гүүрийн зураг төсөл



Зам, гүүр, байгууламж

- Авто зам
- Гүүр, хоолой
- Төмөр зам
- Инженерингийн байгууламж
- Материалын үйлдвэрлэл
- Авто зам, гүүрийн төслийн менежмент
- Авто зам, гүүрийн тооцоо, зураг төсөл



Мэргэжилтнүүд

Манай компани барилгын иж бүрэн зураг төсөл, угсралт, төслийн менежментийн ажил үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, арга техникийг эзэмшсэн чадварлаг мэргэжилтнүүдээр баг хамт олноо бүрдүүлсэн ба залуу авьяаслаг боловсон хүчнээр эгнээгээ байнга тэлж тасралтгүй сурган хөгжүүлж байна.

Манай компани одоогоор 113 гаруй инженер, архитектор, дизайнеруудтэй бөгөөд түүнээс 6 Зөвлөх инженер, 18 Мэргэшсэн инженер, архитектор, төсөвчинтэй үйл ажиллагаагаа эрхэлж байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зарчим

Бидний нэн тэргүүний зорилт бол үйлдвэрлэлийн осол гаргахгүй, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүй, байгаль орчинд хор хөнөөлгүй ажиллах явдал юм

Аюулгүй ажиллагааны үндсэн зарчмууд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал
- Аливаа ослоос урьдчилан сэргийлэх боломжтой
- Ажлын байрны аюулгүй байдлыг хангах нь хүн бүрийн үүрэг хариуцлага
- Хүн бүр өөрийн ажлын байран дахь аюул ослыг урьдчилан тодорхойлж аюулгүй ажиллагааг удирдан зохицуулах үүрэгтэй
- Хуулиар хүлээсэн үүрэг болон салбарын стандартууд нь ерөнхий ХАБЭА-ны шаардлагууд
- Эрсдэлийн менежментийн хүрээнд хүн бүр сургалтанд хамрагдаж осол аюулгүй ажлын байрыг бий болгох мэдлэг, ур чадварыг эзэмшин, осол, аюулгүй байдлыг хангах эх үүсвэрүүдээр хангагдсан байна.

Чанарын хяналт ба баталгаа

Чанар бол ПиСиДиПи компаний үйл ажиллагаа, гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт бөгөөд зураг төсөл, барилга угсралтын чанараараа Монголын барилгын салбарт тэргүүлэх байр суурийг эзлэх, байр сууриа бататгах, цаашид тасралтгүй хөгжин дэвших зорилттой. Бид Захиалагч, үйлчлүүлэгч, хэрэглэгч (ашиглагч)-ийн хэрэгцээ шаардлагыг бүрэн ойлгож, түүнд нийцсэн ажил үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд, холбогдох стандарт шаардлагын дагуу тогтмол хүргэж ажиллана.

Бидний ажил үйлчилгээ нь Захиалагчийн хүлээлтэнд нийцэн чанарын гурвалжингийн дараах үзүүлэлтүүдийг хангасан байна:

- Хүлээн зөвшөөрөгдсөн чанар, стандартыг хангана
- Өрсөлдөхүйц үнэ, төсөвтэй
- Тохиролцсон хугацаанд гүйцэтгэнэ



PCDP

Монгол улс, Улаанбаатар 14230
Сүхбаатар дүүрэг, Нарны зам 91,
Санроуд билдинг, V давхар



Info@pcdp.mn



7711 7196



7711 7195